



СҮХБААТАР АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/04

Баруун-Урт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29, 31 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дүгээр тогтоолоор баталсан Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам, аймгийн Засаг даргын 2023 оны А/663 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчийн газрын дүрэм"-ийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад заагдсан хөрөнгийн дуудлагын худалдааг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Орон нутгийн өмчийн төлөөлөл	Г.Баадай	- Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Дуудлагын худалдааны хөтлөгч	Ц.Адъяасүрэн	- Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч	Б.Ууганцэцэг	- Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Дуудлагын худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (Г.Баадай)-т үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.АЛТАННАР

2224010035